

**ҮХЦ-д гомдол, мэдээлэл
гаргасан үндэслэл**

Төрийн болон албаны нууцын тухай хууль

- 13.2.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь энэ зүйлийн 13.1-д заасан жагсаалтын хүрээнд салбар, байгууллагын хэмжээнд нууцлах төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг боловсруулж, тагнуулын байгууллагын саналыг авч Засгийн газраар батлуулна.
- 14.1.Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална.

ҮХЦ-д ХАНДСАН МЭДЭЭЛЛИЙН
ДАРААЛАЛ

2019.10.0
7

ҮХЦ-д мэдээлэл гаргав

2019.10.2
5

ҮХЦ-ийн гишүүн
Г.Туулхүүгээс Маргааан
хянан шийдвэрлэх
ажиллагаа үүсгэхээс
татгалзах тухай 167
тогтоол гарсан.

2020.01.
13

Үндсэн хуулийн цэцэд
гомдол гаргав.

2020.02.
17

Гомдлыг цэцийн гишүүн
нэгтгэн шалгахаар
шийдвэрлэн 22 дугаар
тогтоол гаргасан.

2020.03.
18

ҮХЦ-ийн магадлал
гарсан



МОНГОЛ УЛСЫН
ҮНДСЭН ХУУЛЬ

МУЗГ-ын 2017.09.13-ны өдрийн 246 дугаар ТОГТООЛ, ТҮҮНИЙ ХАВСРАЛТ

1	Хавсралт 1	МУ-ын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам
2	Хавсралт 1-1	Нууцтай танилцах эрхийн түвшинг нотлох лавлагааны бүртгэл
3	Хавсралт 4	Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам
4	Хавсралт 1-2	Төрийн болон албаны нууцтай танилцах эрхийн зөвшөөрөл
5	Хавсралт 5	Төрийн болон албаны нууцыг хамгаалахад туслалцаа дэмжлэг үзүүлсэн иргэн, хуулийн этгээдийг урамшуулах журам
6	Хавсралт 3	Төрийн болон албаны нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, ашиглах журам

Үндсэн хуулийн зөрчил гэж үзэж буй үндэслэл

- Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсний “. . . хууль дээдлэх . . .”
- Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтын “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэсний “. . . улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төрийн . . . нууцыг хуулиар тогтоон хамгаална”

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД
МЭДЭЭЛЭЛ ГАРГАХ НЬ

2019 оны 10 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын иргэн С.Номынбаясгалан, Б.Пүрэвсүрэн нар нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, Засгийн газрын 246 дугаар тогтоол, түүний хавсралт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтыг зөрчсөн тухай мэдээлэл хүргүүлж байна.

Үндэслэгээ:

Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон албаны нууцын тухай хуульд “Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь энэ хуулийн 13.1-д заасан жагсаалтын хүрээнд салбар, байгууллагын хэмжээнд нууцлах төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг боловсруулж, тагнгуулын байгууллагын саналыг авч Засгийн газраар батлуулна” гэж зохицуулсны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 246 дугаар тогтоолоор Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг баталсан. Энэ нь төрийн нууцтай холбоотой асуудлыг зөвхөн хуулиар тогтоож байх үндсэн хуулиар тусгайлан тогтоосон шаардлагыг алдагдуулж, төрийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар бус харин гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага болох Засгийн газрын тогтоолоор батлагдсан журмаар тогтоож байна. Ийнхүү төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох хууль дээдлэх зарчим зөрчилгөж, хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн тэнцвэрт байдлыг алдагдуулан, хуулийн биелэлтийг хангах учиртай. Засгийн газар үндсэн хуулиар олгогдоогүй эрх хэмжээ бүрэн эрхийг эдэлж, хэрэгжүүлэхэд хүргэсэн байна.

Иймд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь энэ хуулийн 13.1-д заасан жагсаалтын хүрээнд салбар, байгууллагын хэмжээнд нууцлах төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг боловсруулж, тагнгуулын байгууллагын саналыг авч Засгийн газраар батлуулна” гэсний “. . . Засгийн газраар батлуулна” гэсэн нь, мөн түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт батлах тухай” 246 дугаар тогтоол, түүний хавсралт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсний “. . . хууль дээдлэх . . .” гэснийг, Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтын “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбат зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэсний “. . . улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төрийн . . . нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэснийг тус тус зөрчсөн тул хянан хэлэлцрэх дүгнэлт гаргаж өгнө үү. |

Үндэслэл:

Зг-аар батлуулахаар хуульчилсан нь төрийн нууцад хамаарах мэдээллийг шинээр тогтоох эрх олгосон асуудал биш байх бөгөөд харин хуулиар тогтоосон төрийн нууцын хүрээнд байгууллага, салбарын хэмжээнд нууцлах мэдээллийн уялдаа холбоог хангах, хуулийн зохицуулалтыг салбар харгалзахгүй нэг мөр, үр дүнтэй улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулахад чиглэгдэж байна.

МУҮХ-ийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгийн 7.3 дахь заалтад “Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөл, мэдээллийг шийдвэрлүүлэхээр тавьж буй асуудал нь МУЗГ-ийн шийдвэр байгаа тохиолдолд Цэцэд хандахаас өмнө ҮХ-ийн 45.2 дахь хэсэгт зааснаар ЗГ болон УИХ-д хандсан байх бөгөөд уг нөхцөлийг хангаагүй тохиолдолд хүлээн авахгүй.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД
ГОМДОЛ ГАРГАХ ТУХАЙ

2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Иргэн С.Номынбаясгалан, Б.Пүрэвсүрэн нараас 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн "Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь энэ хуулийн 13.1-д заасан жагсаалтын хүрээнд салбар, байгууллагын хэмжээнд нууцлах төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг боловсруулж, тагнуулын байгууллагын саналыг авч Засгийн газраар батлуулна" гэсний ". . . Засгийн газраар батлуулна" гэсэн нь, мөн түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13 –ны өдрийн "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт батлах тухай" 246 дугаар тогтоол, түүний хавсралт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсний ". . . хууль дээдлэх . . ." гэснийг, Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтын "Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална" гэсний ". . . улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төрийн . . . нууцыг хуулиар тогтоон хамгаална" гэснийг тус тус зөрчсөн тул хянан хэлэлцэж дүгнэлт гаргаж өгнө үү гэсэн мэдээлэл гаргасан.

Мэдээллийн дагуу Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.Туулхүүгээс 2019.10.25-ны өдөр Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзах тухай 167 дугаар тогтоол ирүүлсэн. Тогтоолын үндэслэх хэсэгт "Үндсэн хуулийн эрх зүй болон онолын суурь, зарчмын дагуу Улсын Их Хурал хуулийн хүрээнд холбогдох бүрэн эрхээ Засгийн газарт шилжүүлсэн гэж үзэх үндэслэлтэй байна" гэжээ. НҮБ-ын Хүний эрхийн хорооноос гаргасан тайлбарын дагуу төрийн нууцын жагсаалтыг зөвхөн хуулиар тогтоох шаардлагатай билээ. Засгийн газар нь хуулиар гагц нууц мэдээллийг нууцлах шаардлага тавигддаг тул Улсын Их Хурал хуулийн хүрээнд бүрэн эрхээ Засгийн газарт шилжүүлснийг зөвхөн ойлгохгүй юм.

Азийн сангийн 2019 онд хэрэгжүүлсэн "Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээ" судалгааны тайланд нийт 33 байгууллага, салбарт хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээллийн тоо 60, Засгийн газрын тогтоолоор төрийн нууцад хамааруулсан мэдээллийн тоо 565 болж эрс өссөн. Энэ нь 2017.09.01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд заасан төрийн нууцад хамаарах мэдээллийн тоог Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор хэд дахин нэмэгдсэн болохыг харуулж байна. Үүнээс гадна, албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг төрийн

байгууллагын удирдлага өөрөө батлахаар тусгасан тул нууцалсан мэдээллийн жагсаалтын нэгдсэн тоо дээр дурдсанаар хязгаарлагдахгүй юм. Ингэснээр, мэдээлэлтэй байх эрхийг тодорхой шалгуурын дагуу зөвхөн хуулиар хязгаарлах тухай Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн зохицуулалт зөрчигдөх, хууль гаргахгүйгээр аливаа мэдээг төрийн болон албаны нууцад хамааруулах замаар иргэдийн мэдээлэлтэй байх эрхийг зохих үндэслэлгүйгээр хязгаарлах үр дагавар бий болоод байна.

Иймд гомдлыг хянан хэлэлцэж Үндсэн хуулийн маргаан үүсгэж өгнө үү.

Гомдол гаргасан: С.Номынбаясгалан / /
Утас: 95110999
Гомдол гаргасан: Б.Пүрэвсүрэн / /
Утас: 99128391




МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн **МАГАДЛАЛ ГАРГАХ НЬ:**

- 1. ТБАНТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална.” гэж заасан нь ҮХ-ийн 16.17 дахь заалтын, “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.” гэснийг зөрчсөн эсэх асуудлаар ҮХЦ маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсүгэй.

- 2. МУҮХ-ийн цэцийн гишүүний 2020.01.06-ны өдрийн “Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзах тухай” 02 дугаар тогтоолын ТБАНтХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг ҮХ-ийн 16.17 дахь заалтыг зөрчсөн эсэх асуудлаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан хэсгийг хүчингүй болгож, бусад хэсгийг хэвээр үлдээсүгэй.
- 3. МУҮХ-ийн цэцийн гишүүний 2019.10 дугаар сарын 25-ны өдрийн “Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзах тухай” 167 дугаар тогтоолыг хэвээр үлдээсүгэй.

График 2. Төрийн нууцад хамаарах мэдээллийн тооны өсөлт, 1995-2019



Нийт 33 байгууллага, салбарт хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээллийн тоо 60, Засгийн газрын тогтоолоор төрийн нууцад хамааруулсан мэдээллийн тоо 565 байна. Үүнээс төрийн нууцад хамааруулсан онц чухал зэрэглэлтэй мэдээллийн тоо 54, маш нууц зэрэглэлтэй мэдээллийн тоо 527 байна. Энэ нь 2017.09.01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд заасан төрийн нууцад хамаарах мэдээллийн тоог Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор хэд дахин нэмэгдсэн болохыг харуулж байна.

График 1. Төрийн болон албаны нууцын тухай хууль болон Засгийн газрын тогтоолоор төрийн нууцад хамааруулсан мэдээллийн нэгдсэн тоо



МЭДЭЭЛЭЛТЭЙ БАЙХ
ЭРХИЙГ ХЯЗГААРЛАЖ БУЙ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ДҮН ШИНЖИЛГЭЭ
https://www.gic.mn/public/docs/publications/public_restrictions_right_to_information_act_s_pdf_2019.pdf



БИД ХЭРХЭН ХАМТРАН АЖИЛЛАХ ВЭ?



**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**
